

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.04.22-04.26

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн S&P 500 болоод Nasdaq индексүүд өсөлттэй хаагдсан бол Dow Jones индекс буурч хаагдлаа.

Мэдээлэл технологийн салбарын хамгийн том төлөөлөгч болох "Microsoft" компанийн 2019 оны I улирлын санхүүгийн үзүүлэлт шинжээчдийн таамгаас сайн гарсан байна. Ингэснээр "Nasdaq"-ийн биржийн Пүрэв гарагийн арилжаагаар тус компанийн хувьцааны ханш өсөн, зах зээлийн үнэлгээ нь 996 тэрбум ам.долларт хүрч, "Microsoft" компани дахин дэлхийн хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани болжээ.

Харин томоохон аж үйлдвэрийн конгломерат болох "3M" компанийн хувьцааны ханш огцом буурч, Dow Jones индекст сөргөөр нөлөөлжээ.

Цахилгаан автомашин үйлдвэрлэгчдийн томоохон төлөөлөл болсон "Tesla Motor" компани энэ оны эхний улирлыг 494 сая ам.долларын алдагдлаар эхлүүлээ. Шинжээчид I улиралд тус компанийн нэгж хувьцаанд ногдох алдагдлыг 1.3 ам.доллараар тооцоолж байсан бол тайлант хугацаанд алдагдал нь 2.9 ам.доллар болж нэмэгдсэн байна.

"Facebook"-ийн зар сурталчилгааны бизнес тус компанийн борлуулалтын орлогыг өсөхөд нөлөөлөв. "Facebook" компанийн I улирлын борлуулалтын орлого 26 хувиар өсөж, 15.1 тэрбум ам.долларт хүрсэн нь зах зээлийн хүлээлтийг давсан үзүүлэлт боллоо.

"Amazon.com" компани хүргэлтийн хугацаагаа хоёр өдөр байсныг нэг өдөр болгохын тулд II улиралд 800 сая ам.доллар зарцуулахаар болсон байна.

Энэ долоо хоногт газрын тосны үнэ хэлбэлзэл өндөртэй байлаа. Даваа болон Мягмар гарагт АНУ Ираны эсрэг хоригоо чангатгаж байгаа талаар мэдээлж, газрын тосны ханш сүүлийн зургаан сарын дээд түвшинд хүрч өсжээ. Харин Пүрэв, Баасан гарагт АНУ-ын газрын тосны нөөц 2017 оны 10-р сараас хойшхи хамгийн дээд түвшинд хүрсэн талаар мэдээлэл гарч, газрын тосны ханш огцом буурсан байна.

АНУ-ын ДНБ өсөлт 2019 оны санхүүгийн жилийн I улиралд 3.2 хувь болж эргэн сэргэлээ. Ийнхүү тус улсын эдийн засгийн өсөлт I улиралд 2015 оноос хойш анх удаа гурван хувийг давж байна.

Европ: Европын хөрөнгийн захын STOXX Europe 600 индекс бага хэмжээний өсөлт үзүүлээ. Европын хувьцаат компаниудын 26 орчим хувь 2019 оны I улирлын тайлангаа нийтэд ил болгосон байна. Одоогийн байдлаар эдгээр компаниудын 48 хувь нь шинжээчдийн таамгийг давсан үзүүлэлттэй байна.

Европын бүсийн эдийн засгийн өсөлт удааширч байгаатай холбогдуулан еврогийн ханш ам.долларын эсрэг сүүлийн 2 жилийн доод түвшинд хүрч суларлаа.

Япон: Японы төв банк энэ оны 4-р сарын 23-24 өдрүүдэд болсон Мөнгөний бодлогын зөвлөлийн хуралдаанаараа бодлогын хүүний түвшиндээ өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэлээ. Тус байгууллага 2019 оны инфляцийн таамаг түвшинг 0.9% хувьд үлдээсэн бол 2020 оны инфляцийн таамаг түвшинг 1.4 хувиас 1.3 хувь болгон бууруулжээ.

Япон улсад "Алтан долоо хоног" тохиож байгаатай холбоотойгоор тус улсын хөрөнгийн биржүүд 4-р сарын 26-ны өдрөөс 5-р сарын 7-ны өдөр хүртэл 10 өдөр амрах ажээ.

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,231.64	1.76% ▲
Dow Jones	АНУ	26,543.33	-0.06% ▼
S&P 500	АНУ	2,939.88	1.20% ▲
Nasdaq	АНУ	8,146.40	1.85% ▲
S&P/TSX	Канад	16,613.46	0.00% ▲
FTSE 100	Их Британи	7,428.19	-0.42% ▼
S&P/ASX 200	Австрали	6,385.60	2.01% ▲
Nikkei 225	Япон	22,258.73	0.26% ▲
Hang Seng	Хонг Конг	29,605.01	-1.20% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	110.72
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	98.80
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.36
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.50
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.07
DBM' 2023	USD	7.250%	102.37
TDBM' 2020	USD	9.375%	103.40

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.483	0.00 ▲
Libor 3M	2.580	0.00
Libor 6M	2.610	-0.02 ▼
Libor 1YR	2.717	-0.03 ▼
US 2YR Bond	2.282	-0.09 ▼
US 3YR Bond	2.247	-0.10 ▼
US 5YR Bond	2.288	-0.09 ▼
US 10YR Bond	2.498	-0.07 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.04.26	Өөрчлөлт
USD	2,639.51	0.14% ▲
CNY	391.78	-0.35% ▼
EUR	2,940.15	-0.80% ▼
RUB	40.80	-1.02% ▼
KRW	2.27	-2.16% ▼
JPY	23.64	0.38% ▲
CAD	1,958.38	-0.66% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,286.16	0.83% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.09	0.35% ▲
Зэс	USD/lb.	289.40	-1.11% ▼
Нүүрс	USD/MT	86.62	-0.59% ▼
WTI газрын тос	USD/bbl.	63.30	-1.09% ▼
Brent газрын тос	USD/bbl.	72.15	0.25% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.57	3.21% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. III	6.70%
Бодлогын хүү	2019. III	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. III	10.94%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. III	12.06%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. III	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. III	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. III	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 396.4 сая төгрөгийн 2,493,422 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 25.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 75.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Өндөрхаан” /ONH/ компанийн хувьцаа 14.89%-аар буурч 8,000.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


4-р сарын 26-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,352.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,231.64 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.76%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	396.1
Зах зээлийн үнэлгээ	2,352,735.6

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,231.64	1.76% ▲
MSE I индекс	9,028.47	2.85% ▲
MSE II индекс	8,134.64	0.44% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард даатгал	110,711	75,950,586
Ард кредит ББСБ	672,073	52,265,122
Жинст-Увс	22,957	44,279,991
АПУ	562,762	37,342,451
ЛэндМН ББСБ	56,633	32,846,272

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	75.00	25.00% ▲
МИК Холдинг	11,480.00	9.33% ▲
Айтүүлс	88.81	8.80% ▲
Хархорин	1,760.00	6.67% ▲
Ард даатгал	709.28	4.75% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Өндөрхаан	8,000.00	-14.89% ▼
Дөрвөн-Уул	900.00	14.29% ▼
Шарын гол	1,613.00	-10.39% ▼
Жуулчин дютти фрий	100,800.00	-10.00% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корп.	460.00	-5.77% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секьюритиз	227,826,913
Бумбат-Алтай	67,887,422
Голомт капитал	65,206,744
Ти Ди Би Капитал	61,479,409
Би Ди Сек	59,442,220

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	589.99	627,856
Таван толгой	6,485.00	341,534
МИК	11,480.00	237,743
Говь	290.57	226,677
Сүү	211.68	72,818

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дютри фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монос хүнс” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалга эхэллээ

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Монос Хүнс” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, “Монос Групп” ХХК-ийн Ерөнхийлөгч Л.Хүрэлбаатар, “Монос Групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Ананд, “Монос Хүнс” ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Отгондарь, “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал О.Мөнхжаргал нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,956 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

“Монос Хүнс” ХК нь эрүүл мэндийн салбараас анх удаа олон нийтэд үнэт цаасаа санал болгож байгаа компани бөгөөд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх болон техник технологийг сайжруулах зорилгоор нийт хувьцааныхаа 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2019 оны 4 дүгээр сарын 22-ноос 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 10:00-17:00 цагийн хооронд Монголын хөрөнгийн биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шүүгчийн 2019 оны 4-р сарын 24-ний өдрийн 183/ШЗ2019/05036 тоот захирамжийн дагуу “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 3-р сарын 14-ний өдрийн 01/02 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхээр болсон байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Тахь-ко” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Тахь-ко” ХК-ийн 2018 оны татварын дараах ногдол ашиг болох нийт 110.6 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 97.20 төгрөг тараасныг 2019 оны 4-р сарын 24-ний өдөр өөрийн 629 хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Ч.Хүрэлбаатар: 2021 оноос бондын өр төлж эхэлнэ

Засгийн газрын 4-р сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танилцууллаа. Сангийн яамнаас Монгол Улсын эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2020-2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, мөн Засгийн газрын өрийн удирдлагын стратегийг хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхийг дэмжсэн байна.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, “Монгол Улсын эдийн засаг 2020 онд 6.3 хувь, инфляцийн түвшин 8 хувьтай байна гэж тооцсон. Мөн гадаад худалдааны тэнцэл нэг тэрбум ам.долларын ашигтай байхаар тооцож байна. 2020 онд төсвийн алдагдал ДНБ-ний эзлэх хувь хэмжээгээр 5.1 хувьтай байхаар тооцсон нь энэ оныхоос 0.3 функтээр сайжрах юм.

Ирэх онд Засгийн газраас хэрэгжүүлэх үндсэн чиглэлд нийт 37 их наяд төгрөгийн санхүүжилттэй 400 гаруй ажил тусгах санал ирсэн. Үүнээс санхүүжих эх үүсвэр, хэрэгжих боломжтой нь уялдуулаад нийт 10 их наяд төгрөгийн 116 ажлыг үндсэн чиглэлд тусгалаа. Тухайлбал, Улсын төсвөөс хэрэгжүүлэх ажилд 6 их наяд төгрөгийн санал ирсэн. Үүний 3.4 их наяд төгрөгийн ажлыг хэрэгжих боломжтой гэж үзээд, төсөвт суулгасан. Мөн урсгал зардалд 3.7 их наяд төгрөг төсөвлөх санал ирснээс 1.3 их наяд төгрөгийг нь тусгасан.

Төсвийн мэдэгдэлд тодорхой хэмжээний зардал суулгаж өгсөн. Төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 9.2 хувь байсныг ирэх онд 8.6 хувь болгож бууруулахаар тооцсон.

Засгийн газрын өрийн байдал, 2016 оны төгсгөлд, ДНБ-ний 78.8 хувийг эзэлж байсан бол, өнгөрсөн оны төгсгөлд 58.9 хувь болж буурсан. Төсөвт дарамт болдог барих, шилжүүлэх ажлыг энэ онд хийхгүй. Арилжааны хувьд, дотоод, гадаадын бонд авахгүй гэсэн бодлогыг баримталж байгаа. 2021 оноос томоохон бондуудын өр төлж эхэлнэ. Тухайлбал Мазаалай бондын 600 сая ам.доллар, 2022 онд Чингис бондын нэг тэрбум ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая ам.доллар, 2024 онд Хуралдай бондын 600 сая ам.доллар зэрэг нийт 2.9 тэрбум ам.долларын өрийг төлөх учиртай. Энэ төлбөрийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүй төлөх стратегийг боловсруулж өгсөн. Цаашид гадаад зээлийг авахдаа, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр ашгийг сайтар тооцож байж авах хэрэгтэй.

Улсын төсөв энэ оны эхний улирлын байдлаар, 196 тэрбум төгрөгийн ашигтай байна. Өрийн хэмжээ ДНБ-ний 93 хувьтай тэнцэж байсан үе бий. Харин дээрх арга хэмжээг авснаар, Засгийн газрын өрийг ДНБ-ний 54 хувьтэй болгож бууруулахаар төлөвлөсөн.

Эх сурвалж: Montsame.mn

“Rio Tinto” Лондоны Хөрөнгийн биржид бүртгэлтэй энгийн хувьцаанаасаа 75,700 ширхгийг авав

“Rio Tinto” компани “J.P Morgan Securities”-ээс Лондоны Хөрөнгийн биржид бүртгэлтэй өөрийн энгийн хувьцаанаасаа 75,700 ширхгийг худалдан авсан гэдгээ мэдэгдлээ.

“Rio Tinto” 2019 оны хоёрдугаар сарын 28-аас 2020 оны хоёрдугаар сарын 28 хүртэлх нэг жилийн хугацаанд нийт 5.4 тэрбум ам.долларын дүнд хувьцаа эргүүлэн худалдан авах төлөвлөгөө танилцуулаад байгаа юм. Шинэ худалдан авалтыг энэхүү шийдвэрийн хүрээнд хийсэн байна. Дээрх худалдан авалтын дараа зах зээлд гүйлгээнд байгаа энгийн хувьцааных нь тоо 1,272,760 мянга болох юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 53 хувиар өслөө

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 3-р сард өмнөх оны мөн үеэс 53 хувиар өсөж, 6.1 сая тонн хүрлээ. Өсөлтийн хувь нь 2017 оны 4-р сараас хойших хамгийн өндөр дүнд тооцогдож байна.

Коксжих нүүрсний импортыг оны эхний гурван сарын байдлаар авч үзвэл 35 хувиар өсөж, 16.4 сая тонн хүрсэн байна. Харин эрчим хүчний нүүрсийг оруулаад нүүрсний нийт импортыг тооцвол 3-р сард 12 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Өнгөрсөн сард коксжих нүүрсний импорт өндөр дүнгээр өссөн нь 2-р сард Сар шинийн баяр тохиож арилжаа хумигдаад 3-р сард эргээд сэргэсэнтэй холбоотой гэж тайлбарлаж байна. Мөн шинжээчид 4-р сард коксжих нүүрсний импортын дүн доошилж гарах магадлалтай гэж үзэж байгаа аж.

БНХАУ-ын эрх баригчид гадны улсуудаас орж ирж байгаа нүүрсний чанарын шаардлагаа өндөрсгөж байгаа юм. Ялангуяа радио идэвхт агууламжийг нягтлан шалгах болжээ. Мөн Австралиас орж ирж буй нүүрсний гаалийн бүрдүүлэлт хийх явцыг удаашруулж ачааны хөлөг онгоцнуудыг боомтод гацаах байдал 1-р сараас үүсэж эхэлсэн байна.

Харин 3-р сард БНХАУ Монгол Улсаас анх удаа 3.3 сая тонн буюу хамгийн их хэмжээгээр коксжих нүүрс худалдан авчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 44 хувиар өссөн дүн болж байгаа юм.

Дурдсан хугацаанд Австралиас 2.2 сая тонн коксжих нүүрс импортолсон байна. Ингэснээр БНХАУ-д нийлүүлж байгаа коксжих нүүрсний хэмжээгээр Монгол Улс Австралийг давж гараад байна.

Дараагийн нэгэн томоохон нийлүүлэгч болох ОХУ 3-р сард БНХАУ-д 417 мянган тонн коксжих нүүрс нийлүүлжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 100 гаруй хувиар өссөн дүн болж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Монголбанкны худалдаж авсан алтны хэмжээ өмнөх оны мөн үеэс 48 хувиар бага байна

2019 он гарснаас хойш 4-р сарын 25-ны өдрийг хүртэл Монголбанк 1.6 тонн алт худалдаж авсан болохоо мэдээллээ.

Энэ нь өмнөх оны мөн үеэс 48 хувиар буурсан үзүүлэлт юм. Оны эхний саруудад алт тушаалт буурсан нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлтийг сунгах хуулийн төсөл батлагдаагүй байсантай холбоотой гэж Төв банк тайлбарлаж байна. Хууль батлагдсаны дараа буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр таван хувь болсноос хойш 837 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 11 хувиар өсжээ. Төв банк гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх нэг гол арга хэрэгсэл нь алт худалдан авалт гэж үзэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.

"Mongolian Mining Corporation"-ийн нүүрс олборлолт 30 хувиар өсөж, 10.9 сая тонн хүрчээ

"Mongolian Mining Corporation"-ийн нүүрс олборлолт 2018 онд 30 хувиар өсөж, түүхэн дээд хэмжээ 10.9 сая тонн хүрсэн байна. Мөн жилийн тайланд тусгаснаар зах зээлийн ханш харьцангуй өндөр байсан нь орлого өмнөх жилүүдийн дээд түвшин 590 сая ам.доллар хүрэхэд дэмжлэг болжээ.



Тус компани энэ хугацаанд 4.8 сая тонн угаасан коксжих нүүрс боловсруулсан байна. "Mongolian Mining Corporation"-ийн тайланд дурдсанаар нүүрс экспортлоход тулгарч байгаа гол хүндрэл нь Ганцмод-Гашуунсухайтын боомтын нэвтрүүлэх чадал болж байна. Тухайлбал, өнгөрсөн онд боомтоор нэвтэрсэн нийт ачааны автомашины тоо 20 хувиар буурч, 208 мянга 400 болжээ.

Хамгийн сүүлийн шинэчилсэн тооцоогоор тус компанийн эзэмшил дэх Ухаа худгийн ордын коксжих нүүрсний нийт нөөцийг 311 сая тонноор үнэлж байна. 2018 онд тус ордоос 9.5 сая тонн ялгаагүй нүүрс олборложээ. Харин Баруун Наран ордын нөөцийг 175 сая тонноор тооцож байгаа аж. 2018 оны олборлолт нь 1.4 сая тонн хүрч өсжээ.

"Mongolian Mining Corporation" энэ сард 2024 онд хугацаа нь дуусах, 440 сая ам.долларын бонд гаргаад байна. Эндээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө 194.9 болон 412.5 сая ам.долларын үнэт цаасныхаа тодорхой хэсгийг эргүүлэн худалдаж авахад зарцуулж байгаа талаар мэдээлсэн юм. Зах зээлийг бүхэлд нь харвал Монгол Улсын гол худалдан авагч болох БНХАУ-ын коксжих нүүрсний импорт өнгөрсөн онд 7.2 хувиар буурч, 65 сая тонн болжээ. Үүний 42.7 хувийг Монгол Улсаас нийлүүлсэн байна.

Харин гол өрсөлдөгч Австралийн хувьд БНХАУ-ын нүүрсний импортын 43.6 хувийг бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл Австралийн нийлүүлэлт 8.7 хувиар буурсан бол Монголын нийлүүлэлт 5.3 хувиар өссөн байна. Цаашид БНХАУ түүхий эдийн татан авалтаа аль болох олон улсаас хангах бодлого баримталдаг тул энэ харьцаанд төдийлөн өөрчлөлт гарахгүй гэж "Fenwei"-ийн шинжээчид дүгнэжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn